

“Хөгжиж буй орнуудад зориулсан цаг уурын багажуудын
засвар үйлчилгээ болон ашиглалт”
сэдэвт сургалтад хамрагдсан тухай товч тайлан

2017.07.03

Дэлхийн цаг уурын байгууллага болон БНХАУ-ын цаг уурын байгууллага, БНХАУ-ийн Худалдааны яамны хамтран хэрэгжүүлж буй “Хөгжиж буй орнуудад зориулсан цаг уурын багажуудын засвар үйлчилгээ болон ашиглалт” сэдэвт сургалтад тус төвийн сүлжээ, мэдээллийн сангийн инженер А.Баярмаа 2017 оны 06 дугаар сарын 02-29-ний өдрүүдэд хамрагдлаа. Сургалт БНХАУ-ын Нанжин хот дахь Дэлхийн цаг уурын байгууллагын “Бүсийн сургалтын төв”-д амжилттай зохион байгуулагдаж, сургалтад нийт 12 орны 29 инженер, техникийн ажилчид хамрагдсан ба үүнээс Монгол улсаас 5, Судан 5, Замбиа 3, Тонга 1, Венесуэл 1, Уганда 1, Палестин 2, Куба 3, Гана 3, Рванда 3, Гренада 1, Зимбабе 1 суралцагч тус тус оролцлоо.

“Хөгжиж буй орнуудад зориулсан цаг уурын багажуудын засвар үйлчилгээ болон ашиглалт” сургалт нь нийт 28 өдрийн турш батлагдсан хөтөлбөрийн дагуу явагдаж, БНХАУ-ын электроникийн хамгийн том үйлдвэрлэгч компани болох Sun Create компанийн үйл ажиллагаа болон Хуаниан хотын цаг уурын үйлчилгээтэй танилцсан.

Sun Create компани нь нийтэд зориулсан ухаалаг дохиолол, хамгаалалтын систем, цаг уурын систем, радар, нислэгт зориулсан агаарын хөдөлгөөний удирдлагын системийн үйлдвэрлэлээрээ улсдаа тэргүүлэгч компани юм.

Сургалтын агуулга: Хятадын цаг уурын байгууллагын үндсэн зорилго, цаг уурын үйлчилгээний чиг үүрэг, цаг уурын багаж, тоног төхөөрөмж, түүний хэрэглээ, ашиглалт, цаг уурын үзэгдлийг багаж, тоног төхөөрөмжөөр хэрхэн илрүүлэх талаар онол, дадлагын ажлуудыг хийсэн. Мөн тоног төхөөрөмжийн ажиллагааны зарчим, тэдгээрийн уялдаа холбооны талаар хамтран туршлага солилцож, дадлага хэлбэрээр үр дүнтэй явагдлаа. Батлагдсан хөтөлбөрийн дагуу онолын хичээлүүдийг сургалтын төв болон Хятадын цаг уурын байгууллагын мэргэжилтнүүд тус тус заасан.

Энэхүү олон улсын сургалтанд хамрагдсанаар Хятадын болон бусад сургалтад оролцогч орнуудын цаг уурын байгууллагын цаг уурын багаж, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, ашиглалт, суурилуулалт, түүний хэрэглээний талаар санал солилцож, туршлага судлаад ирсэн.

Training Course on the Use and Maintenance of Meteorological Instruments for Developing Countries
June 2 to 29, 2017 WMO RTC Nanjing

